

**ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА,
ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГИЙН АСУУДЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Харьцуулсан судалгаа)

*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, Ц. Болормаа
Д. Жигваагүнсэл, Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа*

Сэдвийн агуулга:

Оршил

Монгол Улсын төрөөс дээд боловсролын салбарт баримталж буй бодлого, эрх зүйн орчны мэдээлэл

Нэгдүгээр бүлэг:

- Монгол Улсад төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл тусламжийн хэлбэрүүд
 - 1.1. Төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл тусламжийн хэлбэрүүд /түүхчилсэн лавлагаа/
 - 1.2. Тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд, олгох шалгуур үзүүлэлт, эргэн төлөгдөх нөхцөл
 - 1.3. Тэтгэлэг зээл тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэл
 - 1.4. Дүгнэлт

Хоёрдугаар бүлэг:

- **Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг тусалцааны гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт**
 - 2.1. Өндөр хөгжилтэй орнууд**
 - Австрали
 - Их Британи
 - Турк
 - Швед
 - 2.2. Хуучин Социалист орнууд**
 - ОХУ
 - БНКаз Улс
 - БНБел Улс
 - 2.3. Азийн орнууд**
 - Энэтхэг
 - Япон
 - Солонгос
 - Монгол
 - 2.4. Дүгнэлт**

Санал зөвлөмж

Ашигласан материал

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Оршил

УИХ-ын Тамгын газрын СШОНХТөвийн судалгааны баг “Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг тусалцаа, оюутны тэтгэлэгийн асуудал” сэдэвт харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

Монгол Улсад дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн талаархи бодлогыг Дээд боловсролын хуулийн 18-р зүйлд ерөнхийлөн зохицуулсаныг Засгийн газраас баталсан “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”, “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” болон 2001 онд БСШУЯ ба СЭЗЯ-ны сайд нарын хамтарсан 310/290 тоот тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-аар зохицуулагдаж байсан. Харин 2008 онд Засгийн газраас 177-р тогтоол гаргаж дээрхи гурван журмыг нэгтгэн шинэчлэн баталсан юм.

Энэхүү журмын зохицуулалт болон гадаадын зарим орны боловсролын салбарт төрөөс үзүүлж буй дэмжлэг тусалцааны эрх зүйн орчинг харьцуулан судалж манай улсын хувьд авч хэрэгжүүлэх болохуйц туршлага бий эсэхийг тодорхойлох үүднээс энэхүү харьцуулсан судалгааг хийлээ.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд Монгол улсад дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэг тусалцааны асуудлыг 1992 оноос хойш зохицуулж байсан эрх зүйн баримт бичиг болоод өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдийг хамруулсан болно. Түүнчлэн манай улсын төсвөөс 1994-2008 оны хооронд оюутны тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл, тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэлийг дэмжлэг, тусалцааны хэлбэр бүрээр харьцуулан үзүүлсэн юм.

Судалгаанд хамруулсан улс орнуудыг сонгохдоо тухайн орны хөгжлийн үзүүлэлт, сургалтын зээл болон бусад дэмжлэгийн талаархи туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, түүнчлэн сургалтын чанарын үзүүлэлт зэрэг шалгууруудыг голлон өндөр хөгжилтэй орон, Азийн орон, хуучин социалист зэрэг орнуудыг бүлэглэн авч үзсэн юм. Өндөр хөгжилтэй улс оронд Австрали, Их Британи, Турк, Швед, хуучин социалист орнуудад ОХУ, БНКаз Улс, БНБелУлс, Азийн орнуудад Энэтхэг, Япон, Солонгос зэрэг улс орныг багтаан тэдгээрийн холбогдох хууль, журмуудыг Монгол улсын хууль, холбогдох журмуудтай харьцуулан судалсан болно.

Монгол Улсын төрөөс дээд боловсролын салбарт баримталж буй бодлого, эрх зүйн орчны мэдээлэл

Монгол улсын төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогын баримт бичгийг 1995 онд УИХ-аас батлан гаргасан бөгөөд үүнтэй холбогдуулан 1997 онд Монгол улсын Засгийн газраас “Боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл”-ийг баталсан байна.

УИХ-аас баталсан бодлогын баримт бичигт төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогоо тодорхойлохдоо “Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн. Үүнийг үндэслэн боловсролыг төрөөс нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” хэмээн тодорхойлоод тус баримт бичгийн 2-р зүйлийн 1-ийн 1 дэх хэсэгт “боловсролыг төрийн ивээл, дэмжлэг, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад

байлгана” хэмээн заасан байдаг.

Ийнхүү төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогоо тодорхойлж түүндээ нийцүүлэн 2002 онд Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуулиудыг шинэчлэн баталсан. Өдгөө боловсролын салбарын аливаа харилцаа эдгээр хууль болон түүнтэй холбогдон гарсан бусад дүрэм журмуудын хүрээнд зохицуулагдаж байна. Харин төрөөс боловсролын салбарт тэр дундаа их дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны талаар үндсэн зохицуулалтыг Дээд боловсролын тухай хуулийн 18-р зүйлд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

18.1.Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 18.1.1.улсын төсвийн хөрөнгө;
- 18.1.2.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;
- 18.1.3.сургалтын төлбөр;
- 18.1.4.аж ахуйн үйл ажиллагааны орлого;
- 18.1.5.холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу тогтоосон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;
- 18.1.6.зээл, тусламж;
- 18.1.7.бусад эх үүсвэр.

18.2.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулах, багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрөөс зохих дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

18.3.Боловсролын байгууллагад хандивласан хөрөнгийг байгууллагын санхүүгийн тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглана.

18.4.Зайлшгүй шаардлагатай зарим мэргэжлээр гадаадад мэргэжилтэн бэлтгэх сургалтын зардлыг жил бүрийн улсын төсвөөс санхүүжүүлж болох бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хэрэгцээг үндэслэн төрөөс суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилан зохицуулна.

18.5.Өмчийн аль ч хэлбэрийн дээд боловсролын сургалтын байгууллага нь хоёр жил тутамд санхүүгийн үйл ажиллагаандаа аудитын хяналт хийлгэж, дүнг нийтэд ил тод байлгана.

Мөн хуулийн зохицуулалтаас гадна хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас хэд хэдэн тогтоолыг батлан /1-р бүлгээс тодорхой үзнэ үү/ гаргасан бөгөөд түүнд Монгол улсын төрөөс их, дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл хэлбэр тодорхойлогдоно.

Төрөөс үзүүлж буй дэмжлэг, туслалцааны аливаа үйл ажиллагаа тэр дундаа их, дээд сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг 1997 оны Засгийн газрын 179 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн байгуулагдсан Сургалтын Төрийн Сан /СТС/ эрхлэн гүйцэтгэж ирсэн байдаг.

СТС нь 1993 онд анх байгуулагдан, 1997 оны 179 дүгээр тогтоолоор шинэчлэгдсэн журмын дагуу үйл ажиллагаагаа 16 дахь жилдээ явуулж байгаа юм байна. Засгийн газраас холбогдох тогтоолуудаар батлагдсан журмуудын дагуу хагас болон бүтэн өнчин, амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагчид, хөржлийн бэрхшээлтэй суралцагчид, шагналын хэлбэрээр элсэгчид, төрийн албан

хаагчийн гэр бүлээс суралцагч, түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчидтай гурвалсан гэрээ байгуулан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгохын зэрэгцээ зээлийг буцаан төлүүлэх, санхүүжилтийн төсөв, тооцоо хийх, тайлагнах, хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна.

Практик нөхцөл байдалд Монгол Улсын хэмжээнд их, дээд сургуулиудад суралцаж буй нийт оюутнуудаас 28 мянга нь Төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар, 17 мянга нь төрийн албан хаагчийн хүүхэд гэдгээр суралцаж байгаа аж. Өөрөөр хэлбэл, гурван оюутан тутмын нэг нь төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар сурч байгаа гэж судлаачид үзсэн байна.¹

Бэрхшээл асуудал: Үүнээс боловсролын салбарт тулгараад буй гол бэрхшээл асуудал нь төрөөс олгогдож буй зээлийн эргэн төлөлт удаашралтай, хангалтгүй, СТС-ийн төсвийн зарцуулалт багатай байгаа явдал гэж салбарын мэргэжилтнүүд үзэж байна. Үүнд:

- Суралцагчдад олгож буй төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох шалгуур үзүүлэлт боловсронгуй бус
- Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид суралцагчдын сургалтын төлбөрийг тооцох нэгдсэн аргачлал мөрдүүлээгүй
- Гадаадад зэргийн түвшиний сургуульд /магистрантур, докторантур/ суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг зохих ёсоор тогтоогоогүй
- СТС-ийн бодлого тодорхой бусаас шалтгаалан сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсдын хүрээ хэт өргөжсөн
- Зээлийг төлүүлэх оновчтой механизм байхгүй гэж тодорхойлсон байна.

Үүнийг үндэслэн УИХТГ-ын СШОНХТ-ийн судалгааны баг дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн төрөл, хэлбэр, шалгуур үзүүлэлт болон зээлийн эргэн төлөлтийн нөхцөл зэргийг гадаадын зарим орны холбогдох хууль, эрх зүйн актуудаар хэрхэн зохицуулсаныг судалж харьцуулсан хүснэгтээр үзүүлэв.

* * *

Нэгдүгээр бүлэг: МОНГОЛ УЛСАД ТӨРӨӨС ОЛГОДОГ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХЭЛБЭРҮҮД, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН СУДАЛГАА

1.1. Төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд /түүхчилсэн лавлагаа/

1990 -ээд оноос хойш Монголын дээд боловсролын тогтолцоо үндсэндээ өөрчлөгдөж, сургалтын төлбөртэй системд шилжсэн нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгосон. Сургалтын төлбөрийн тогтолцоог нэвтрүүлж, оюутнуудад зориулагдсан зээл, тусламжийн хөтөлбөр бий болгон, дээд боловсролын салбарт хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд үйл ажиллагаагаа явуулах бололцоог нээсэн шинэ шинэ өөрчлөлтүүд нь мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчилсэн чухал алхам болсон.

Засгийн газраас 1992 онд Мэргэжлийн Сургалтын Байгууллагуудыг Санхүүжүүлэх журмыг баталж, боловсролын байгууллагуудын төлбөрийн төвшинг тогтоосон. Үүний дагуу,

¹ ННФ, Зориг сан “Төрөөс боловсролын салбарт үзүүлж буй оюутны сургалтын тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаанд хийх мониторинг” төслийн тайлан, УБ., 2008 он

сургалтын төлбөр, багш ажилчдын цалингийн доод төвшинг тогтоож, 1992-1993 оны хичээлийн жилээс төрийн өмчийн бүх их, дээд сургуулиуд түүнийг мөрдөж эхэлсэн байна. “Төрийн өмчийн мэргэжлийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх тухай” Засгийн газрын 107 дугаар тогтоолоор Сургалтын Төрийн Сан /СТС/ байгуулагдаж, одоогийн сургалтын тусламжийн хөтөлбөрийн үндэсийг бий болгосон.

СТС нь 1992 онд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийг зохицуулах, мэргэжлийн боловсролын сургалтад зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, суралцагчдад төрөөс санхүүгийн баталгаат дэмжлэг үзүүлэх, сургалтын чанарыг урамшуулах, хувийн сургуулийг дэмжих зорилгоор байгуулагдсан байна. Төрөөс СТС-аар дамжуулан сургалтын зээл, буцалтгүй тусламжийг анх ЗГ-ын 107-р тогтоолд заасны дагуу олгож эхэлсэн бөгөөд ингэхдээ оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусалж дэмжих зорилгоор сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, амьжиргааны стипенди, хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн байна.

1995 онд СТС-ын үйл ажиллагааг зохицуулах зээл, тусламж үзүүлэх үйл ажиллагааг хуульчилсан ЗГ-ын 194 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн сургуульд суралцагчдад зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг баталж, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн 1 хүүхэд, өрхийн тэргүүн нь хөдөлмөрийн чадвараа алдсан өрхийн 1 хүүхэд, эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гарсан бага орлоготой өрхийн 2-оос илүүгүй хүүхэд, хагас өнчин хүүхдэд зээл, буцалтгүй тусламж олгохоор заажээ.

1997 онд ЗГ-ын 179 дүгээр тогтоолоор “Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй оюутнуудад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг баталж, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд тэнцсэн магадлан итгэмжлэгдсэн сургуульд элсэн суралцаж буй оюутнууд зээл, буцалтгүй тусламжид хамрагдах эрхтэй хэмээн өргөжүүлжээ. 2000 оны ЗГ-ын 96 дугаар тогтоолоор “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам” батлагдсаны дагуу нэн ядуу болон амьдралын түвшин доогуур суралцагчдыг нэмэн хамруулах болсон.

2000 оны ЗГ-ын 158 дугаар тогтоолоор “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” батлагдаж нэн ядуу, бүтэн өнчин, малчин, бага орлоготой, 3-аас дээш хүүхэдтэй айлын нэг хүүхдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон. Энэ нь нийт СТС-нд хамрагдагсдын 35хувийг эзэлж байсан байна. 2000 оны ЗГ-ын 201 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” баталж, бүх төрлийн их, дээд сургуульд бакалаврын болон дипломын боловсрол эзэмшихээр суралцаж байгаа төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даахаар болжээ. /2000 оноос өмнө төрийн албан хаагчдыг үр дүнтэй дэмжих зорилго бүхий тусгай хөтөлбөрийн хүрээнд тэдгээрийн оюутан хүүхдийн сургалтын зардлын тэтгэлгийг олгодог байжээ/

2001 онд БСШУЯ ба СЭЗЯ-ны сайд нарын хамтарсан 310/290 тоот тушаалаар “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам” баталж, сургалтын зээлд хамрагдагсдын хүрээг өргөжүүлж яамд, аймаг, дүүргийн улсын байгууллагуудад 2 буюу түүнээс олон жил ажилласан хүмүүсийг сургалтын зээл авах эрх олгожээ.

2002 онд “Дээд боловсролын тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу их, дээд боловсролын байгууллагуудыг **их сургууль, дээд сургууль** ба **коллежи** гэж 3 ангилсан. Коллежид 3 жилийн дипломын боловсрол эсвэл 4 жилийн бакалаврын зэрэг, дээд сургуулиуд магистрын зэрэг олгох 1,5-2 жил, их сургуулиуд эдгээрээс гадна докторын /3-5 жилийн/ зэрэг олгох эрхтэй гэсэн өөрчлөлт орсонтой холбогдуулан 2002 оны 10 дугаар сарын 8-ны 207 дугаар тогтоолоор дээрх өөрчлөлтөд зохицуулан өмнө гарсан

бүх тогтоолуудыг шинэчилсэн байна. **2002 оны 207 дугаар тогтоолоор** ядуу малчин өрхийн амьжиргааны үзүүлэлтийн 500 бог мал /2000 оны 158 дугаар тогтоол/ гэдгийг 700 бог мал гэж нэмэгдүүлсэн. Мөн сургалтын төлбөрийн зээлээ эргэн төлж барагдуулсан эсэхээс үл хамааран дипломын хуулбарыг төгсөгчдөд төгссөн даруйд нь олгоно гэсэн заалт оруулсан.

2006 оны 3Г-ын 55 дугаар тогтоолоор төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын гэр бүлээс нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд, мэргэжлийн сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд элсэн орсон 1 хүүхдийн нь сургалтын төлбөрийг төрөөс олгохоор нэмж тусгасан байна. 2008 оны 3Г-ын 177 дугаар тогтоолоор өмнө гарсан “Журам батлах тухай” 3Г-ын 96, 158, 207 дугаар тогтоолуудыг хүчингүй болгон дахин өөрчлөн боловсронгуй болгож, сурлагын амжилт гаргасан, амьдралын түвшин доогуур, хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцаж буй оюутанд монгол улсын иргэн, дотоодын сургуульд суралцагч гадаадын оюутныг хамруулахаар болжээ. Өнөөг хүртэл нийтдээ сургалтын байгууллагын тэтгэлэг, зээл, тусламжийн талаар 10 -аад журам батлагдан мөрдөгдөж ирсэн байх бөгөөд жил ирэх тусам зээл тусламжид хамрагдсагсдын төрөл, цар хүрээ улам өргөжин тэлсээр иржээ.

1.2. Тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд, олгох шалгуур үзүүлэлт, эргэн төлөгдөх нөхцөл

СТС -гаас сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаа 1993 - 1995 онд оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусалж дэмжих чиглэлээр эхэлсэн бол 1996-1999 онд нэн ядуу болон амьдралын түвшин доогуур өрхийн 1 хүүхдэд, 2000 оноос хойш ядуу, өнчин, малчин, бага орлоготой, төрийн албан хаагчийн хүүхдэд зээл, буцалтгүй тусламж олгох, 2003 оноос сумдад төрийн албан хаагч бэлтгэх зардал гэх мэтээр сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдах оюутнуудын хүрээг өргөжүүлсэн байна.

Төрөөс СТС-аар дамжуулан олгож буй сургалтын зээл, буцалтгүй тусламж нь эргэн төлөгдөх хөнгөлттэй зээл, эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж гэсэн 2 үндсэн хэлбэрээр олгогдож байгаа боловч томьёололын хувьд 3 янз байна. Үүнд:

- Сургалтын төлбөр, зээл
- Сургалтын буцалтгүй тусламж
- Амьжиргааны тэтгэлэг/стипенди/

Сургалтын тэтгэлэг гэдэг нь төрөөс буцалтгүй тусламжийн хэлбэрээр л олгогдож буй оюутны амьжиргааны тэтгэлэг юм. Өөрөөр хэлбэр дээрх үндсэн 2 хэлбэрээр сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, төлбөрийн шагналыг олгодог гэсэн үг юм. Эдгээр зээл, тусламжийн хэлбэр, шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 1.2.1-д үзүүлэв.

Сургалтын төрийн сангаас үзүүлдэг зээл тусламжийн хэлбэр, шалгуур үзүүлэлт

Хүснэгт 1.2.1

Д/д	Тогтоолын он, сар, дугаар	Зээл тусламжийн хэлбэр	Шалгуур үзүүлэлт	Санхүүжүүлэх зардал	Эргэн төлөлт
-----	---------------------------	------------------------	------------------	---------------------	--------------

1	ЗГ-1993-107 “Их сургууль, коллежийн зарим сургалтын төлбөрийн санхүүжилтийн тухай” Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Холбогдох яамдын захиалгын дагуу суралцагсдын сургалтын төлбөр -Онцгой авъяастай оюутнуудын стипенди -Хоёр улсын гэрээгээр суралцаж буй гадаадын болон дотоодын оюутнуудад -Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой суралцагчид	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг стипенди, Нэрэмжит, шагналын стипенди Амжиргааны тэтгэлэг, сургалтын төлбөр төрийн халамж болгон стипенди	-Захиалгаар бэлтгэгдсэн хүнийг захиалагч бус өөр байгууллага авч ажиллуулвал суралцсан хугацааны сургалтын төлбөрийг төрийн санд буцаан төлсөн байна. -Улсын захиалгаар суралцаад захиалагчийн шаардлагыг хангаагүй бол сургалтын төлбөрөө буцаан төлнө.
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	-Төрийн өмчийн мэргэжлийн сургуульд суралцагч Монгол улсын иргэнд -Хувийн сургуулийн тогтмол зардлын 50 хүртэл хувьд зориулж 30 хувийн хүүтэй зээл	Сургалтын төлбөр, стипендид олгоход /Зээлийг тухайн жилийн хэрэгцээнд тохируулан жил бүр олгоно/ Хувийн сургуулийн дотоод үйл ажиллагаанд зориулж олгодог.	-Төгссөнөөс 10 жилийн дотор төлж барагдуулах ба хугацаа хэтэрвэл арилжааны банкны хугацаа хэтэрсэн зээлийн нөхцлийг баримтлана. -Зээлийн хүү 3 хувь, стипендийн хүү 5 хувь байна.
2	ЗГ-1995-194 “Мэргэжлийн сургуульд суралцагчдад зээл, буцалтгүй тусламж олгох тухай” хүчингүй болсон	Төрөөс санхүүжүүлэх /эргэн төлөгдөхгүй/	-Бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллежи, тусгай мэргэжлийн дунд сургуульд төрийн албан хаагчийн гэр бүлээс элссэн нэг оюутаны	Сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.	-Суралцагчийн буруугаас сургуулиа орхисон тохиодолд суралцсан хугацааны зардлыг эргүүлэн төлүүлнэ.
		Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Бүтэн өнчин асран хамгаалагчгүй, тахир дутуу суралцагчийн - бага орлоготой болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн буюу хагас өнчин суралцагчид	-Сургалтын төлбөр, тэтгэлэг, дотуур байрны зардал. -Амьжиргааны тэтгэлэг	Хамааралгүй
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	-Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагчид -Магистрантурт суралцагчид -Багшийн мэргэжлээр суралцагчид -Бага орлоготой суралцагчид -гадаад орны мэргэжлийн сургуульд суралцагчид	-Сургалтын төлбөр -сургалтын төлбөр -тэтгэлэг -сургалтын төлбөр, тэтгэлэг -сургалтын төлбөр, замын зардал	-Төгссөнөөс хойш нэг жилийн дараагаас эхлэн 1-3 хувийн хүүтэйгээр буцаан төлнө. -суралцагч 6 жилийн дотор, магистрант 3 жилд багтаан төлнө. -Зээлийн хүүг зарим нөхцлөөр хөнгөлнө. -Багшийн мэргэжлээр төгсөөд мэргэжлээрээ 6-гаас доошгүй жил ажиллавал тэтгэлгийн зээлийг бүр мөсөн чөлөөлнө. -Нас барсан, тахир дутуугийн 1,2-р зэрэг тогтоогдсон нөхцөлд зээлийн төлбөрийг хүүгийн хамт чөлөөлнө.



3	ЗГ-1997-179 "Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй оюутнуудад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох тухай" хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуугийн группт орсон суралцагч	Суралтын төлбөр, тэтгэлэг	
			Сургалт, эрдэм шинжилгээний ажилд өндөр амжилт гаргасан онцгой авъяас чадвартай суралцагч	Сургалтын төлбөрийг нь 5-р улирлаас эхлэн	
			Олон улсын уралдаан, олимпиадаас эхний 3 байр эзэлсэн суралцагчийн	Эхний 2 жилийн сургалтийн төлбөр	
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Амьжиргааны түвшинээс бага орлоготой, нэн ядуу өрхийн 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон гишүүдтэй өрхийн 2-оос илүүгүй суралцагч	Сургалтын төлбөр	
			Оюуны болон хөдөлмөрийн чадвараа алдсан хараагүй, дүлий иргэд бүхий өрхийн 1 суралцагч	Сургалтын төлбөр	
			Багшийн мэргэжлээр суралцагч	Тэтгэлэг	
			ЗГ-ын гэрээгээр гадаадын суралцагч	Амьжиргааны тэтгэлэг	



4	ЗГ-2000-96 “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам” /хүчингүй болсон/	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн тахир дутуу суралцагч Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой хагас өнчин суралцагч	Сургалтын төлбөр, тэтгэлэг Нэг жилийн сургалтын төлбөрийн 150.0 мянган төгрөгийг	
		Төлбөрийн шагнал /эргэн төлөгдөхгүй/	-Олон улсын хэмээнд зохиогдсон олимпиад, о.у-ын дээд зэрэглэлийн уралдаан тэмцээнд шагналт байр эзэлсэн, -ЕБС-ийг төгсөх жилээ улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн -Сурлагын амжилт үзүүлсэн суралцагч	Сургалтын төлбөрийн шагнал	
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	Эргэн төлөлтийн тухай заалт байхгүй байна.

5	ЗГ-2000-158 “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” /нэмэлт өөрчлөлт орсон/ /хүчингүй болсон/	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Нийт малыг нь богд шилжүүлснээр 700 хүртэл толгой мал бүхий зөвхөн малчин өрхийн -Бүсийн амьжиргааны түвшингийн 40 хувиас бага орлоготой ядуу өрхийн суралцагч -3 ба түүнээс дээш хүүхэд нь их дээд сургууль, коллежид зэрэг суралцаж буй өрхийн нэг суралцагч	Сургалтын төлбөрийг нь төрөөс санхүүжүүлнэ.	Хамааралгүй \жич: Хөнгөлөлттэй зээл болон бусад зүйлийн талаар заалт байхгүй байна\
6	ЗГ-2000-201 “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” /дэгдэж байгаа/	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Төрийн албан хаагчийн их, дээд сургуульд суралцаж байгаа 1 хүүхдийн	Сургалтын төлбөрийг төрөөс даана.	Хамааралгүй /бүх хэлбэрийн их дээд сургуульд суралцаж буй суралцагчид хамрагдана/
	БСШУЯ-ны сайд, СЭЗЯ-ны сайдын хамтарсан тушаал №310/290 /мөрдөгдөж байгаа/	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Өндөр хөгжилтэй оронд шалгаруулалтын дагуу суралцах эрх авсан суралцагчийн	Сургалтын зардал, тэтгэлэг	Хамааралгүй /“Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, доктарантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”/-аар зохицуулна.

7	ЗГ-2001-195 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-500 хүртэл бог малтай малчин өрхийн -60 хувиас доогуур орлоготой ядуу өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөр	
			-Сумдаас ирсэн захиалгын дагуу эмч, багшаар ажиллахаар гэрээ хийсэн суралцагчийн	2 жилийн сургалтын төлбөр	
8	ЗГ-2002-207 Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж	-700 бог малтай малчин өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөр	Хамааралгүй
9	ЗГ-2003-61 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай/ Хүчингүй болсон	Зээлээс чөлөөлөх	-	-	35-р зүйлийг "Суралцагч сургууль төгсөөд холбогдох яам агентлагаас өгсөн чиглэлийн дагуу төрийн захиргаан болон төрийн үйлчилгээний байгууллагад мэргэжлээрээ нийслэлд 8 жил, аймгийн төвд 5 жил, суманд 2 жил үр бүтээлтэй ажиллавал хөнгөлөлттэй зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлж болно " гэж өөрчилжээ.
10	ЗГ-2006-55 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын гэр бүлээс нь магадлан итгэмжлэгдсэн их дээд мэргэжлийн сургуульд 2005-2006 онд элсэн орсон 1 суралцагчийн	Сургалтын төлбөрийг төрөөс олгох	Хамааралгүй



11	11. Журам шинэчлэн батлах тухай, ЗГ-2008-177 Мөрдөгдөж байгаа	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн оюутан	Сургалтын төлбөрийг	Хамааралгүй /суралцагчдын голч дүн 2,8-2,0-оос доошгүй байх шаардлага тавигддаг. /
			Олон улсын зэрэглэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд МУ-ыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа МУ-ын иргэнд	Амьжиргааны тэтгэлэг	
			Бүтэн өнчин суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	Сургалтын төлбөрийг	
			Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч	Сургалтын төлбөрийг	
			өрхийн нэг хүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 50 хүртэл толой мал ногдох малчин өрхийн нэг суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			ЗГ хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэний	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг	
	Хөнгөлөлттэй зээл /Эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Хөнгөлөлттэй зээл /Эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Харас өнчин суралцагчид	Сургалтын төлбөр	-төгссөнөөс хойш 5 жилийн дотор төлж барагдуулна. -суралцагч зээлийн гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийн хүүгийн хамт буцаан төлнө. -суралцагч нас барсан, хөдөлмөрийн чадвараа 70 болон түүнээс дээш хувиар алдсан тохиолдолд түүнийг зээлийн төлбөрөөс чөлөөлнө. -суралцагч нийслэлд төсвийн байгууллагад 5-аас доошгүй жил, орон нутагт төсвийн байгууллагад 3-аас доошгүй жил тогтвортой, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд мөн зээлээс чөлөөлнө.
			Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 100 хүртэл толгой мал ногдох зөвхөн малчин өрхийн суралцагч	Сургалтын төлбөр	
			Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч	Сургалтын төлбөр	
			Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч	Сургалтын төлбөр	
			Олон улсын нэр хүндтэй гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, э.ш-ний ажлын хамгаалах зардал	

* **

Эх сурвалж: МУ -ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Засгийн газрын тогтоолууд. УИХТГ-ын СШОНХТ 2009 он

Сургалтын төрийн сангийн зээл буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь орлого багатай ядуу боловч сурах чадвартай оюутнуудад санхүүгийн туслалцаа үзүүлэх явдал юм. Зээл тусламжид хамрагдах гол шалгуур үзүүлэлт нь амьжиргааны түвшин, төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхэд, сурлагын үзүүлэлт ба оюуны онцгой авьяас, чадвар зэргийг харгалзан тэдгээрт тавигдах шаардлагыг үндэслэл болгож байна.

Мэргэжлийн сургуульд суралцагч нь сургалтын тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд хоёр төрлийн тусламж авах эрхтэй бөгөөд энэ нь эргэн төлөгдөх нөхцөлтэй **зээл**, эргэн төлөгдөх нөхцөлгүй **буцалтгүй тусламж** юм.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл ба эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламжийн аль аль нь сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг санхүүжүүлдэг. Нэг оюутанд ногдох тусламжийн хэмжээ нь сургалтын төлбөрийн хэмжээ, оюутны өрхийн орлогын төвшин болон гэртээ эсвэл гэрээсээ хол байдаг эсэхээс хамаардаг. Өөрөөр хэлбэл эргэн төлөгдөх зээл ба эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж хоёулаа сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх бөгөөд хамрагдах шалгуур нь сурлагын болон амьжиргааны төвшин дээр тулгуурладаг болно.

2000 оноос өмнө бүх хэвшлийн их дээд сургууль коллежид суралцаж буй суралцагчид зээл тусламжид хамрагдах боломжтой байсан бол 2000 оноос зөвхөн Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчид олгохоор болсон. 1993 оноос хойш төрөөс олгодог зээл, буцалтгүй тусламж нь хэлбэрийн хувьд дээрх эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламж, эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийн хэлбэрээр, нэр төрөл хамрах хүрээний хувьд Хүснэгт 1-д дурдсанчлан өргөн хүрээтэй олгогдсоор ирсэн байна. Тухайлбал:


- Хөнгөлөлттэй зээл- энэ нь суралцагчид төрөөс олгож буй тэтгэлгийн нэг хэлбэр бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогддог бага хувийн хүүтэй зээл юм. Хөнгөлөлттэй зээлийн хүү нь арилжааны банкны хүүгээс маш бага буюу 1-3 хувийн хэлбэлзлэлтэй байдаг байна. Хөнгөлөлттэй зээлийг 1993 оноос эхэлж олгосон. Өмнө нь суралцагч суралцах хугацаандаа авсан хөнгөлөлттэй зээлийг төгссөнөөс хойш 10 жилийн дотор төлж барагдуулдаг байсан бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЗГ-ын 2008 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 177 дугаар тогтоолоор төгссөнөөс хойш 5 жилийн дотор төлж барагдуулах журамтай болсон. Хөнгөлөлттэй зээлийг магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцаж буй хагас өнчин, амьжиргааны түвшин доогуур, гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хаасан зэрэг болзлыг хангасан 2,8 баллаас доошгүй голч дүнтэй суралцагч авах эрхтэй юм.
- Буцалтгүй тусламж- суралцагчид төрөөс олгож буй дэмжлэгийн нэг хэлбэр бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлгүй олгогддог тэтгэлэг юм. 1993 оноос ЗГ-ын 107 дугаар тогтоолын журмын дагуу буцалтгүй тусламж, тэтгэлгийг олгож эхэлсэн бөгөөд бүтэн өнчин, нэн ядуу, сурлагын амжилт үзүүлсэн суралцагчид олгож байсан бол 2000 оноос Төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг оюутан хүүхдэд сургалтын тэтгэлэг олгох болсноор буцалтгүй тусламжид хамрагдагсдын тоо эрс нэмэгдсэн байна. Буцалтгүй тусламжийн төрөл нь сургалтын төлбөрийн тэтгэлэг, амьжиргааны тэтгэлэг /стипенди/, сургалтын төлбөрийн шагнал, унааны зардал зэргээр олгогдож байна. 2008 оноос хойш буцалтгүй тусламж олгох шалгуур үзүүлэлтийг нарийвчилж, сургалтын ямар төрлийг санхүүжүүлэхийг тодорхой зааж өгсөн байна.

1.3. Тэтгэлэг, зээл, тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэл.

Төрөөс дээд боловсролын салбарт сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаа 1993 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2008 он хүртэл нийт 414 мянган оюутанд 124 тэрбум 190 сая төгрөгийн зээл, буцалтгүй тусламж олгосон байна. CTC-аас 1994-

2008 онд зээл, тусламжид хамрагдсан оюутны тоо, санхүүжилтийг жил бүрээр харуулав.
Хавсралт 1.3.1, График 1.3.1/

График №1.3.1



* * *


Дээрх үзүүлэлтээс үзэхэд 1994 - 2000 он хүртэл СТС-аар дамжуулан зөвхөн сургалтын төлбөр, амжиргааны тэтгэлгийг санхүүжүүлэх эргэн төлөгдөх нөхцөлтэй **290,1 - 3928,8** тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг дунджаар 6000-8000 оюутанд олгож байсан бол 2000 оноос буцалтгүй тусламжийг төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхэд, нэн ядуу өрхийн суралцагчид, малчин бага орлоготой өрхийн суралцагчдад олгож эхэлснээр зээл, тусламжид хамрагдагсдын тоо, зардал эрс нэмэгдэж дунджаар 22455 - 51687 оюутанд 8183,5-18625,9 тэрбум төгрөгийн зээл буцалтгүй тусламжийг олгосон үзүүлэлттэй байна.

* * *



СТС -ын тэтгэлэг, зээл, тусламжийг ангилал тус бүрээр авч үзье:

/График №1.3.2/

**1994-2008 онд зээл, тусламж олгосон байдал
/ангилал тус бүрээр/****Тайлбар:** СТС-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

* * *

СТС -аар дамжуулан сургалтын зээл, тусламжийг олгосон байдлыг ангилал тус бүрээр авч үзвэл нийт 119377 оюутанд 22954.8 тэрбум төгрөгийн **хөнгөлөлттэй зээл**, 132321 оюутанд 35582.7 тэрбум төгрөгийн **буцалтгүй тусламж**, **төрийн албан хаагчийн 1 хүүхдийн сургалтын төлбөрийг** 137944 оюутанд 36583.3 тэрбум төгрөг, **өндөр хөгжилтэй оронд магистр, докторантурт суралцагч** 2715 оюутанд 28141.9 тэрбум төгрөгийг сургалтын зээл, буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон байна. Үүнээс гадна 2007 оноос баруун 5 аймгаас ирж суралцаж буй оюутнуудад амралтаараа гэртээ ирж буцах замын зардлын тал хувийг СТС-аар дамжуулан олгож ирсэн бөгөөд энэ хугацаанд 22615 оюутанд 756,3 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

2004 - 2008 төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сургуулиудад суралцагчдын санхүүжилтыг авч үзвэл:

/График 1.3.3/

**Тайлбар:** СТС-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.


* * *

Одоогийн байдлаар Мэргэжлийн боловсролын сургалтын чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг 151 их, дээд сургууль, коллежи байгаагаас 48 нь төрийн өмчийн, 98 нь төрийн бус өмчийн сургууль байна.² Түүнээс 2004 - 2008 онд сургалтын зээл, тусламжид хамрагдсан байдлыг авч үзвэл төрийн өмчийн сургуульд суралцагчид нийт зээл тусламжид хамрагдагсдын 71 хувийг буюу 150871 оюутанд 41321791,3 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн сургуульд суралцагчид 29 хувь буюу 64599 оюутанд 16485415,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. /Хавсралт 2-оос дэлгэрэнгүй үзнэ үү/

Энэ нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчдаас зээл, тусламжид хамруулах болсонтой шууд холбоотой юм. Төрөөс дээд боловсролын салбарын сургалтын зээл, тусламжид зарцуулдаг хөрөнгө төсвийг сургалтын төрийн санд төвлөрүүлдэг байна.

БСШУС -ын төсвийн багцаас дээд боловсролын салбарын сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан байдлыг авч үзвэл: График №1.3.4



Тайлбар: CTC-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

БСШУС-ын төсвийн багцаас дээд боловсролын салбарын сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан байдлыг 2005-2008 оны төвийн гүйцэтгэлээр нь судлан үзэхэд нийт төсвийнхөө 8-9 орчим хувийг эзэлж байна.

1.4. Дүгнэлт

Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны нэг хэлбэр болох оюутны сургалтын зээл, тусламжийг **хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн** хэлбэрээр нэн ядуу, оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй суралцагчдыг дэмжих зорилгоор 1993 оноос хойш олгож ирсэн байна. Гэвч 2000 оноос нэн ядуу, өнчин, малчин, бага орлоготой, төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцах болсноор зээл, тусламжид хамрагдах суралцагчдын цар хүрээг нэмэгдүүлжээ.

Сургалтын зээл, тусламж олгож эхэлсэнээс хойш “Мэргэжлийн сургуульд суралцагчдад

² www.pmis.gov.mn “Дээд боловсролын өнөөгийн байдал” танилцуулга. УБ., 2009 он

зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг хэд хэдэн удаа шинэчлэн өөрчилж байсан бөгөөд одоогоор ЗГ-ын 2008 оны 177 дугаар тогтоол, 2001 оны 201 дүгээр тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өмнө гарсан журмуудад зээл, тусламжийг санхүүжүүлэх төрөл, нэр томъёолол нь бүрхэг, ерөнхий шинжтэйгээс гадна шалгуур үзүүлэлт оновчтой бус хэтэрхий өргөн хүрээг хамарсан, эргэн төлүүлэх журмыг тодорхой бус байдалтайгаар тусгасан байсан бол 2008 оны дээрх тогтоолд эдгээр асуудлыг тодорхой боловсронгуй болгон зохицуулжээ.

Сургалтын зээл, буцалтгүй тусламжийг олгохдоо магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцаж буй хагас өнчин, амьжиргааны түвшин доогуур, гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан зэрэг шалгуурыг хангасан 2,8 баллаас доошгүй голч дүнтэй суралцагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр **хөнгөлөлттэй зээл**, бүтэн өнчин, нэн ядуу, сурлагын амжилт үзүүлсэн суралцагч, төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг оюутан хүүхдэд сургалтын тэтгэлгийг **буцалтгүй тусламж** хэлбэрээр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгоно гэсэн шалгуур үзүүлэлтийг баримталдаг байна.

Одоогоор сургалтын зээл, тусламжийг төрийн сангаар дамжуулан суралцагчийн **сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийг** /зөвхөн гадаадад суралцаж буй оюутанд/ санхүүжүүлэхэд зориулан олгож байгаа бөгөөд 1993-2009 он хүртэл нийт 414 мянган оюутанд 124 тэрбум 190 сая төгрөгийн зээл, буцалтгүй тусламж олгосон байна. Олгож буй зээл, тусламжийн 40 гаруй хувийг Төрийн албан хаагчийн нэг хүүхдэд олгодог буцалтгүй тусламжийн тэтгэлэг зээлж байгаа бол нэн ядуу өрхийн суралцах чадвар сайтай оюутанд олгож буй буцалтгүй тусламжийн тэтгэлэг зээл тусламжид хамрагдагсдын 35 хувийг, үлдсэн нь бусад төрөл болон зээлийн үйлчилгээнд хамрагдагсад эзэлж байна. Зөвхөн Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчид хамрагдах эрхтэй болсноос хойш зээл тусламжид хамрагдагсдын 70 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцагч, 30 хувь нь төрийн бус өмчийн сургуульд суралцагч байна.

Боловсрол болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын хяналтын тоог жил бүрийн 5 дугаар сард мэргэжил тус бүрээр баталдаг бөгөөд төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагч нэг оюутанг энэ тоонд хамруулдаггүй. Түүнээс гадна бодит нөхцөл байдлыг харгалзаагүйгээс СТС-ийн зээл, тусламжид хамрагдаж чадахгүй үлддэг байна. Тухайлбал: Төрийн өмчийн сургуулиудад хүсэлт гаргасан суралцагчдын 57,3 хувь нь сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан байна.³ Энэ нь сургалтын зээл, тусламжид хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан хэдий ч суралцаж буй сургуульд өгсөн хяналтын тооноос хамаарч түүнд хамрагдах оюутны тоо хязгаарлагддаг болохыг харуулж байна.

Төрийн албан хаагчдын нэг оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс буцалтгүй тусламжаар олгож байгаа нь нэг талдаа хавтгайруулан хамруулсан мэт боловч тодорхой шалгуурыг өндөрсгөж нүдээ олж өгвөл төсвийн багахан цалингаар амьдралаа залгуулдаг тэдэнд чухал нэмэр болдог нь илэрхий юм. Амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой боловч онцгой амжилт гаргаагүй ч суралцах чадвар сонирхолтой дундаж амьдралтай өрхийн суралцагчдад төрийн албан хаагчдын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даана гэсэн дэмжлэгээс өөр хамрагдах тодорхой дэмжлэг байхгүй байна.

Мөн төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг нь 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө СТС -ийн зээлээр суралцаж төгссөн 21 мянган төгсөгчийн 8 тэрбум төгрөгийн зээл, түүний хүүгийн төлбөрийг ЗГ-ын 2004 оны 22 дугаар тогтоолоор, Өндөр хөгжилтэй

³ УИХ -ын ЭЗБХ-ны саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. УБ., 2007 он

орны магистр, докторантурт хөнгөлттэй зээлээр суралцан ирээд эх орондоо үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн зээл, түүний хүүгийн төлбөрийг 2008 оны ЗГ-ын 178 дугаар тогтоолоор тус тус чөлөөлсөн явдал юм. Сургалтын зээл, түүний хүүг төлүүлэлгүй чөлөөлсөн нь сургалтын зээлийн агуулга ач холбогдлыг бууруулсан хэдий ч оюутны СТС-ийн хөнгөлттэй зээлд хамрагдах сонирхолыг нэмэгдүүлсэн.

* * *

**Хоёрдугаар бүлэг: ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БҮЙ
ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**
/Харьцуулсан судалгаа/

Судалгааны хоёрдугаар бүлэгт гадаадын зарим орны төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг, туслалцааны төрөл, түүний хэлбэр, оюутнуудад үзүүлэх зээл, тэтгэлэгийн төрөл, түүнийг олгох шалгуур үзүүлэлт, зээлийг эргэн төлөх нөхцөл журам, тэтгэлэгээс хасагдах болон тэтгэлэг олгохгүй байх хууль зүйн үндэслэл болон төрөөс боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааг хариуцан зохион байгуулж хэрэгжүүлж буй бие даасан байгууллага байдаг эсэх талаар голлон анхаарч холбогдох хууль, журмуудын эрх зүйн зохицуулалтыг ерөнхийд нь харьцуулан судалсан болно.

Судалгаанд хамруулсан улс орнуудыг сонгохдоо тухайн орны хөгжлийн үзүүлэлт, сургалтын зээл болон бусад дэмжлэгийн талаархи туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, түүнчлэн сургалтын чанарын үзүүлэлт зэрэг шалгууруудыг голлон өндөр хөгжилтэй орон, Азийн орон, хуучин социалист зэрэг орнуудыг бүлэглэн авч үзсэн гэдгийг дээр дурьдсан билээ. Судалгаанаас үзэхэд, Эдгээр улс нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиас гадна тухайн орны эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарсан бие даасан хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмуудын дагуу дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийг зохицуулдаг байна. Түүнчлэн хууль тогтоомжоос гадна төрийн бус байгууллага болон бусад олон улсын статустай байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг сургалтын тэтгэлэг хөтөлбөр олныг хэрэгжүүлдэг бөгөөд тус судалгаанд зөвхөн төрөөс баримталж буй бодлогыг авч үзсэн учраас хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд нь асуудлыг судалсан юм.

Судалгаанд хамрагдсан улсуудын хууль тогтоомжоос үзэхэд дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн хэлбэрийг дараахь байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж буй сургалтын төлбөрийг төр хариуцах. Ийм бодлого баримталж буй улс оронд Турк, Энэтхэг, Швед, ОХУ, БНКаз Улс зэрэг улс орон багтдаг байна.
- Төрийн өмчийн их дээд сургуулийн барилга, байгууламж, сургалтын орчны зардлыг төрөөс хариуцах. Турк, Энэтхэг, Швед гэх мэт улс орнууд
- Сургалтын төлбөрийн зээл:
 1. Хүүтэй зээл
 2. Хүүгүй зээл
- Оюутны дотуур байрны зардлыг төр хариуцах
- Сургалтын ном хэрэгсэлээр хангах
- Оюутны эрүүл мэндийн үйлчилгээ
- Унааны зардал
- Оюутны тэтгэлэг .

Судалгааны харьцуулалт хамрагдсан ихэнхи улс оронд оюутны тэтгэлэг олгох эрх зүйн

зохицуулалттай бөгөөд тэтгэлэг олгох шалгуур үзүүлэлт болон тэтгэлэг олгохгүй байх шалгуур үзүүлэлт, тэтгэлэгээс хасах үндэслэл зэрэг асуудлыг хууль болон харийвчилсан дүрэм журмуудаар зохицуулсан байна.

Түүнчлэн оюутанд олгох тэтгэлэгийн хэмжээ жил бүрд харилцан адилгүй байх ба судалгааны харьцуулалтанд хамрагдсан улс орны эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн жилийн амьжиргааны түвшин, инфляцийн хувь хэмжээг харгалзан Боловсролын яамтай зөвшилцөн Сангийн яам, Засгийн газраас тогтоодог байна. Сургалтын төлбөрийн зээл болон сургалтын тэтгэлэгт хамрагдах хуульд заасан шалгуур үзүүлэлтийн хувьд улс орон бүрт харилцан адилгүй шалгууруудыг хуульчилсан боловч үндсэн шалгуур нь амжилттай суралцсан болон өрхийн орлогоос хамаардаг болох нь харагдаж байна. Түүнчлэн Турк, Их Британи зэрэг улс орны хувьд сургалтын төлбөрийн зээл болон тэтгэлэг олгохоос татгалзах үндэслэлүүдийг хуульд тусгайлан заасан байна.

Энэхүү бүлэгт тухайн орнуудын их, дээд сургууль, тэдгээрт суралцаж буй оюутнуудад төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл, түүн дотроо оюутнуудын тэтгэлэгийн төрлийг ялгаж үзүүлэх зорилгоор “төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл”, “тэтгэлэгийн төрөл” гэсэн доорхи харьцуулсан хүснэгтээр үзүүлсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээлэл авахийг хүсвэл судалгааны эх сурвалж болж буй вэбсайт болон СШОНХТ-ийн холбогдох судлаачдаас судалгаанд хамрагдсан хууль тогтоомжийг бүрэн эхээр үзэж болох юм.

* * *



**Гадаадын зарим орнуудын төрөөс оюутнуудад олгож буй тэтгэлэгийн төрлүүд,
эрх зүйн зохицуулалтын харьцуулсан хүснэгт**

Хүснэгт 2.

Эрх зүйн актууд	Тэтгэлэгийн хэлбэр	Тэтгэлэг олгох шалгуур үзүүлэлт	Тэтгэлэгээ хасах, олгохгүй байх тохиолдол	Хариуцсан байгууллага
1. Турк Улс -Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль -Тэтгэлэг, зээлийн журам Эх Сурвалж: http://www.mevzuat.adalet.gov.tr/html/1051.html http://mevzuat.meb.gov.tr/html/88.html	-Гадаад оюутны тэтгэлэг -Дотоод оюутны тэтгэлэг -Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	Доорхи тохиолдлоос бусад үндэслэлээр тэтгэлэг олгоно: -Бусад улсын байгууллагуудаас тэтгэлэг авдаг бол -Цалингийн доод хэмжээ болон түүнээс дээш тогтмол цалинтай ажилд ажилладаг бол -Тэтгэлэгт бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил улиран суралцсан бол -Гадаадын сурагчид -Цагдаагийн академи болон бусад цэргийн сургуулийн сурагчид -Сургууль төгсөх болсон боловч төгсөлгүй нэмэлт жилдээ суралцаж байгаа сурагчид -Магистрантур болон докторантурын хэлний бэлтгэл бүлэгт суралцаж байгаа сурагчид -Тэтгэлэг авах шаардлагагүйд тооцогдсон сурагчид	Сургалтын амжилтыг харгалзан хасна. -Хэрэв оюутан гуравдугаар курстээ нэгдүгээр курсын мэргэжлийн хичээлүүдээс 3 болон түүнээс дээш хичээлд унасан тохиолдолд -Нэг улиралд 4 болон түүнээс дээш хичээлд унасан тохиолдолд	Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллага



<p>2. Их Британи</p> <p>-Оюутныг дэмжих тухай хууль /Higher Education act, part4 Student support act/</p> <p>Эх сурвалж:</p> <p>www.opsi.gov.uk/ACTS/acts2002/ukpga_20020032_en_1</p>	<p>-Сургалтын төлбөрийн тэтгэлэг</p> <p>-Амьдралын зардлын тэтгэлэг</p>	<p>-Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт байх</p> <p>-Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болон тус улсад чөлөөтэй орж гарах</p> <p>-Оюутан болон түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харъяат бол</p> <p>-Оюутан тус улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан бол</p> <p>-Боловсролын хуульд заасан бусад тохиолдолд</p>	<p>Оюутан доорхи нөхцөлүүдэд тэтгэлэгт хамрагдах эрхгүй:</p> <ul style="list-style-type: none"> -Тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагч өмнө нь ямар нэгэн тэтгэлэг авсан бол -Тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд зээлд хамрагдаж байгаа бол -Өмнө нь авсан зээлээ төлөхдөө дотоодол гаргасан бол -Тухайн оюутныг тэтгэлэг болон зээл авах шаардлагагүй гэж үзсэн бол 	<p>-Засгийн газар</p> <p>-Ассамблей</p>
<p>3. Япон</p> <p>Эх сурвалж</p> <p>http://www2.jasso.go.jp/about_jasso/index_e.html</p> <p>http://www.mext.go.jp/english/reform/index.htm</p> <p>http://www.mn.emb-japan.go.jp/</p>	<p>-Гадаад оюутны тэтгэлэг</p>	<p>- Их дээд сургуулийн дүнгийн голч-3,2</p> <p>- Өмнө нь Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байсан бол эх орондоо ирсэнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн байх</p> <p>- Өмнө нь Япон улсын тэтгэлэгт хамрагдаж байгаагүй байх</p> <p>-Эрүүл мэндийн хувьд эрүүл байх</p> <p>- Насны хязгаарт заасан насны дотор байх</p>	<p>- Японы их, дээд сургуульд суралцаж байгаа хүн хамрагдах боломжгүй.</p> <p>- Өмнө нь өөрийн Засгийн газар болон олон улсын байгууллагын ямар нэгэн тэтгэлэгээр суралцаж байгаагүй байх</p>	<p>Тухайн улсад нь байгаа Элчин сайдын яам</p>



<p>4. Солонгос</p> <p>Боловсролын суурь хууль</p> <p>Тэтгэлэг олгох журам</p> <p>Эх сурвалж: www.studyinkorea.go.kr www.ied.go.kr www.klaw.co.kr</p>	<p>-Гадаад оюутны тэтгэлэг</p> <ul style="list-style-type: none"> • Бүтэн тэтгэлэг /Сургалтын төлбөр, цалин, судалгааны зардал, эрүүл мэндийн даатгал, онгоцны зардал/ • Хагас тэтгэлэг /зөвхөн сургалтын төлбөр хамаарна/ 	<p>Сургууль бүр харилцан адилгүй шалгуур тавидаг. Нийтлэг тавигддаг шалгууруудад:</p> <ul style="list-style-type: none"> - Англи болон солонгос хэлний өндөр мэдлэгтэй /Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 5 эсвэл 6-д тэнцсэн байх/ - Эрүүл мэндийн хувьд эрүүл - Өмнө нь БНСУ-д визний хугацаа хэтрүүлэн амьдарч байгаагүй 	<p>-Өмнө нь өөр тэтгэлэгт хамрагдаж байсан - Амжилттай суралцаж чадаагүй - Тэтгэлэгийн хугацаандаа чөлөө авсан бол - 2 улсын харьяалалтай бол</p>	<p>Боловсрол, шинжлэх ухаан, Технологийн яам</p>
--	--	---	--	--

* * *



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гадаадын зарим орны төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг
тусалцааны эрх зүйн орчны харьцуулсан хүснэгт

№	Улс	Эрх зүйн актууд	Төрийн дэмжлэгийн хэлбэр	Эзэл болон бусад дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлт	Эзэлнэг эргэн төлөх журам	Хүснэгт 2.1
• Өндөр хөгжилтэй орнууд						
1.	Турк улс Эх Сурвалж: http://www.mevzuat.adaliet.gov.tr/mil1051.html http://mevzuat.meb.gov.tr/hm1058.html	Үндэсний боловсролын тухай хууль	-Сургалтын төлбөрийг улс даах -Тэтгэлэг олгох -Эзэл олгох -Скөөтны дотуур байрын төлбөрийг улс даах	-Ажилттай сурсан -Ажилгээны түвшин дотуур	Дээд боловсролын эзэл, тэтгэлэг олгох тухай хуульд заасан журмын дагуу	-Дээд боловсролын эзэл, өсөөтны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам -Сангийн зам
	Дээд боловсролын эзэл, өсөөтны дотуур байрны байгууллагын тухай хууль	-Их дээд боловсролын эзэл олгох -Тэтгэлэг олгох -Скөөтнуудыг дотуур байраар хэжгэх	-Их дээд сургуульд сурах -Ажилттай сурах -Эзэл авах хэрэгцээ шаардлагатай эсэх		Дээд боловсролын эзэл, тэтгэлэг олгох тухай хуульд заасан журмын дагуу	-Дээд боловсролын эзэл, өсөөтны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам
	-Дээд боловсролын эзэл, тэтгэлэг олгох тухай хууль -Тэтгэлэг, эзэлнэг журмын	-Их дээд боловсролын эзэл олгох -Тэтгэлэг олгох	Хуульд заасан эзэл олгохоос татгалзахаас бусад тохиолдолд сургалтын эзэл олгоно. Эзэл олгохоос татгалзан тохиолдол: -Бусад улсын байгууллагуудад тэтгэлэг авдаг бол -Цалигийн дээд хэмжээ болон түүнээс дээш тогтмол цалинтай ажилд ажилладаг бол -Тэтгэлэг бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил уншсан суралцсан бол -Гадаадын суралцагч -Цагдаагийн академ болон бусад цэргийн сургуулийн суралцагчид -Сургууль төгсөх болсон боловч	-Бакалаврын сургалтын дараагаар засвартайгаар элсэн суралцагчид магистр, докторын сургуулид төгссөн жилээсээ хойш 2 жилийн дараагаас эхлэн, -Бакалаврын сургалтын дараагаар засваргүйгээр магистрын сургалтанд элсэн суралцагчид төгссөнөөс хойш 4 жилийн дараагаас эхлэн, -Бакалавр болон магистрын сургалтын дараагаар засваргүйгээр докторын сургалтанд элсэн суралцагчид төгссөнөөс хойш 2 жилийн	-Дээд боловсролын эзэл, өсөөтны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам -Сангийн нам	

			төгсөлгүй нэмэлт жигдээ суралцаж байгаа сурагчид -Магистрантур болон докторантурын хэлний бэлтгэл бүлэгт суралцаж байгаа сурагчид -Тэтгэлэг авах шаардлагагүйд тооцогдсон сурагчид	дараагаас эхлэн Эзэл төлөх хугацаа: -Эзэлэнд хамрагдсан хамтастай тэнцэх хугацаанд барагдүүлна. -Сургууль шилжин суралцсан тохиолдолд эзэл төлөх хугацаа шинээр эхлэн орсон сургуулиа төгсөх хугацааны дагуу тооцогдоно. -Эзэл авахаа больсон суралцагчид дээрх заалтуудын дагуу эзэлээ төлнө. -Эрүүл мэндийн шалтгаанаас бусад болон өөрийн хүсэлтээр сургуулиас гарсан сурагчид гарсан өдөрөөсөө эхлэн эзэлээ төлнө.	-Застгийн газар -Ажил эрхлэлт сургалтын нам The Department for Employment and Learning
2. Их Британи Эх сурвалж: www.0981.gov.uk/ACTSacts2012uk/BSA_20120032_en	-Оюутныг дэмжих тухай хууль (Higher Education act, part6 Student support act) -Боловсролын тухай хууль (Education act 2002) -Боловсролын буцалтгүй тусламжийн тухай журам (The Education (Grant) Regulations 1990) -Education (Training Grants) Regulations 1990	-Сургалтын төлбөрийн эзэл -Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж -Тэтгэлэг (оюутны цалин)	Их дээд сургуулийн эзрэг, дээд сургуулийн диплом болох сертификат, мэргэжлийн эзрэг диплом олгох зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрт суралцагчид -Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болом тус улсад чөлөөтэй орж гарах зөвшөөрөл авсан бол -Оюутан ба түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харьяат бол -Их Британийн "Боловсролын тухай хууль"-ийн 11-р бүлгийн 186-р зүйлд заасан бусад тохиолдол	Эзэлдэгч эзэлээ шууд төлөх хэлбэр -Ажил эрхлэлт, сургалтын наманд шууд төлөх -Галтгарын системээр дамжуулан төлөх, -Ажил олгогч цалингаас хасах хэлбэрээр төлөх Гадаадын оюутны эзэл төлөлт -Зараас илүү хугацаагаар Их Британиас гарах тохиолдолд "Ажил эрхлэлт сургалтын нам"-д мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сэр бүрийн түүнтэй өдөр хуваарийн дагуу эзэлээ төлнө. -Хэрэв эзэлдэгчийг хуваарийн дагуу төлж байна гэж үзвэл Ажил эрхлэлт сургалтын нам нь түүнийг орлогоо картгаан төлбөрийг зөвшөөрнө.	-Застгийн газар -Ажил эрхлэлт сургалтын нам The Department for Employment and Learning

3. Австрали Эх сурвалж: www.australian.edu.au/mcas/50881976301/36.html	Дээд боловсролын төрийн дэмжлэгийн тухай хууль /State Grant Education Act 1976/ Оюутнуудад үзүүлэх дэмжлэг тусламжийн тухай хууль /Student assistance act 1973/ Галадын оюутанд зориулсан боловсролын үнчилгээний тухай хууль /Boscaion services for Overseas Students (Assistance Fund Contributions) act 2000/	Дотоодын оюутанд үзүүлэх дэмжлэг: -Сургалтын төлбөрийн дээд буцаалтгүй тусламж; -Оюутан нь тухайн хичээлийн жилд ABSTUDY-ийн схемд заагдсан тусламж дэмжлэгийг авах эрхтэй хангасан бол -Оюутны эцэг, эх, асран хамгаалагчийн нийт орлого күүлд хамааралгүй тэмцээндээ бага бол -Оюутан амжилттай суралцсан бол	Дотоод нэгжүүдийг хангасан боловсрол оюутан нь дээд хамрагдах эрхтэй: -Оюутан тухайн жилд ямар нэгэн сургалтын кетч-борт хамрагдах багаа бол -Оюутан нь тухайн хичээлийн жилд ABSTUDY-ийн схемд заагдсан тусламж дэмжлэгийг авах эрхтэй хангасан бол -Оюутны эцэг, эх, асран хамгаалагчийн нийт орлого күүлд хамааралгүй тэмцээндээ бага бол -Оюутан амжилттай суралцсан бол	Зээлийг бараах журмаар эзэн төлнө: -Зээл авсан оюутан зөвхөн үндсэн зээлээ төлнө. ЗГ оюутны нэрийн өмнөөс хүүгийн өрөнд татаас төлнө. -Оюутан гэрээнд заасан үндсэн зээлээ гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш дараа жилийн 6-р сарын нэгдүгээс эхлэн төлнө. -Оюутан хүсвэл зээлээ гэрээний хугацаанаас нь өмнө төлж болно. -Оюутан зээлээ гэрээний хугацаанд бүрэн төлж чадаагүй тохиолдолд зээлийг оюутны өмнөөс ЗГ төлж, оюутны орлого төлөрхөй түвшинд хүрсний дараа татварын системээр эргүүлэн авч болно.	-Ажил эрхлэлт, боловсрол, сургалт, залуусын хэргийн нам -Employment of Boscaion, Training and Youth Affairs / -Эзэмийн сая /Loan Fund/ -Нэгдсэн орлогын сан /Consolidated Revenue Fund/
4. Швед	Боловсролын хууль	- Тэтгэлэг - Амжилтан - зардал	- 2 талын хэлэлцээр орны оюутан - Нэр заасан магистрын кетч-борт хамрагдах зүсэлтэй		Шведийн институт
• Хуучин социалист орнууд					
5. ОХУ	№126-ФЗ Дээд боловсролын дараах боловсролын боловсролын тухай	Сургалтын зардал, тэр зарцуулах -Оюутны байрны төлбөр -Номын сангийн үйлчилгээ	2 дугаар зүйл. Оюутан дор дурдсан эрхтэй: 3.Төрөөс дээд боловсрол дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын давуу байдлыг хангана;	16 дугаар зүйл. 2 дахь хэсэг 5/ дээд сургуулийн номын санд ном болон мэдээллийн сангаар тэмдэглэн үйлчилгээ 3. ...Оюутны байр нь зүүн зүүн нормат хангасан байна. ...	-Засгийн газар

	<p>-Тэтгэлэг.</p> <p>№16.3.Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын өдрийн ангид суралцаж байгаа оюутнуудад сард 1500 рублийн тэтгэлэг олгоно.</p> <p>Засуу тэтгэлгийг өлгөх журмыг Холбооны Засгийн газар тогтооно.</p>	<p>§16.3. Төрийн өмчийн дээд мэргэжлийн боловсролын байгууллагыг Холбооны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. ОХУ-д амьдарч байгаа 10000 хүн тутамд нэгдөх 176 оюутныг төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад суралцуулах зардлыг санхүүжүүлэх зорилгоор Холбооны төсвийн хөрөнгийн 3 %-аас доошгүй хөрөнгийг дээд мэргэжлийн боловсролд зориулна.</p> <p>-Тазар дуугүйн ЦП гуравтэй, өмчин, эцэг эхийн асрамжгүй үлдсэн оюутны тэтгэлэг ердийнхөөс 50%-иар нүү байна.</p> <p>ОХУ-ын зэвсэгт хүчний аль нэг байгууллагад нэрэг, түрүүч, алагчид алба хаасан өдрийн ангийн оюутнуудын тэтгэлэг ердийнхөөс 50%-иар нүү байна. Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын өдрийн ангийн оюутнуудыг дэмжих зардал холбоор тэтгэлгийн фондыг 25%-иар нэмэгдүүлж олгоно.</p> <p>Нийтийг хамарсан соёл, спорт, урлагийн болон эрүүл мэндийн компанит ажилд хамрагдсан өдрийн ангийн оюутнуудад Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагаас 2 сарын тэтгэлгээ тэмцэх академич-тэтгэлэг олгоно</p>	<p>Оюутны байрын төлбөр нь түүний тэтгэлгийн 5%-иас нүүгүй байна</p>	<p>Казахстан улсын Засгийн газар, ЗГ-ын бүрэн эрх, 151 "Богаша" өлсөм улсын тэтгэлэгт хамрагчдыг</p>	
Б. Казахстан	<p>Боловсролын тухай хууль</p>	<p>-Тэтгэлэг</p> <p>-Улааны зардал</p> <p>-Сургалтын төлбөрийг төр хариуцна</p> <p>-Буцалтгүй тусламж</p>	<p>§35.1. ...Иргэн шалгаруулалтын үндсэн дээр төлбөргүй боловсрол эзэмших эрхтэй</p> <p>§47. Суралцагчдын эрх үүрэг:</p> <p>7. Боловсролын байгууллагад суралцаж байгаа иргэн</p>	<p>-47 дугаар зүйл.</p> <p>13. ... Улсын захиалгаар суралцагчдын өлсө, зуны амралтаар хот хоорондын төмөр зам, автомашин тасмнээс бусад, нэ зардлыг хөнгөлнө.</p>	

Шалгаруулах дүрмийг батлах				
		<p>категорын суралцагчдад Казахстан улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрийн нэр зээсэн тэтгэлэг олгоно. Дээд боловсролын болон шинжлэх ухааны байгууллагад өдөрөөр суралцаж байгаа ахъяаслаг хичээнгүй магиструуд, дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа оюутнуудад төрөөс нэр зээсэн өлгөх тэтгэмжийг дээд боловсролын болон шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтдийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн олгоно.</p> <p>В. Төрийн шалгаруулалтаар үйл ажиллагаа нь төгсгөрсөт болох нь тогтоогдсон төрийн өмчийн боловсролын байгууллагаас бага орлоготой гэр бүлийн суралцагчид тэтгэлэг олгоно. Тэтгэлэг өлгөх журмын, тэтгэмжийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>11. Өмчийн эцэг эхийн асрамжгүй үлдсэн хүүхдийн сургалтын зардалыг улсын төсвөөс бүрэн хэмжээгээр санхүүжүүлнэ.</p>	<p>530. Дээд сургуулийн оюутны эрх үүсвэг хариуцахаг</p> <p>1. Оюутан дор дурдсан эрхтэй:</p> <p>1.1. Беларусь улсын хуулиар тогтоосон нөхцөл журмын дагуу тэтгэлэг авах</p> <p>2. Оюутан дор дурдсан үүрэгтэй:</p> <p>а. 17 шатны дээд боловсролыг улсын төсвийн хөрөнгөөр өдөрөөр, түүний дотор зорилготой гэрээгээр суралцагчдад Беларусь улсын Засгийн</p>	<p>Зээлийн эргэн төлөлт</p> <p>Хуваарьласан газарт 2 жил хэрэглүй хугацаанд амьтгасан бол суралцахдаа зарцуулсан төсвийн хөрөнгийг нөхөн төлнө.</p> <p>Хуваарь газартаа ажиллаж байгаа төгсөгч дээд боловсролын баримт бичиг авсан жилдээ Магистрантур, докторантурт зохих журмын дагуу элсэн суралцсан бол төсвийн хөрөнгийг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөнө</p>

<p>• Азийн орнууд</p>				
<p>В. Энэтхэг</p> <p>Эх Сурвалж: http://www.educationfile.in/act/2006/act.html</p>	<p>Төв Боловсролын Институтын тухай хууль 'Central Education Institutions (Reservation and Admission) Act 2006'</p>	<p>Сургуульд үүрүүлэх дэмжлэг -Төрийн өмчийн бүх сургуулиудад олгох татаас -Сургуулийн байр, сургалтын орчноор хөнгөл -Сургалтын төлбөрийг улс даах Оюутанд үүрүүлэх -Татварыг -Баарны зардал -Унааны зардал</p>	<p>-Хуульд заасан шаардлага хангасан -Дэвшилттэй суралцсан -Төрийн өмчийн сургуулиудын бие дагсан хуулинд заасан шалгуурыг хангасан тохиолдолд</p>	<p>-Хүний нөөц хожлогын нам, Дээд боловсролын газар (Ministry of Human Resource Development, Department of Higher Education)</p>

9. Солонгос	Боловсролын суурь хууль	Дотоодын оюутан-үүдэд - Улс бүрэн дахь - Тэтгэлэг олгох - Зээл олгох Гадаад оюутан-үүдэд: - Тэтгэлэг буюу буцалтгүй тусламж	- Бэлгийн мэргэжлээр суралцагч - Шаард-агатай салбарын мэргэжлээр суралцагч болон судлаач - Адим- засгийн хувьд хүнд хэцүү	-Болсворол, шинжлэл ухаан, технологийн нам -Мэдээлэл харилцааны нам Болсворолын хяналт-ын алба
	Боловсролын бэлтгэл-ийн албан хаагчдын хууль		Сургалтын тэтгэлэг авсан этгээд Их сургууль төгсөө-нөөс хойш 4 жилийн хугацаанд орон нутгийн багш нарын шалгаруулалтад оролцож тэмцсэн тохиолдолд тэтгэлэгт амрагдсан хугацааны хоёрны мэдний хугацаанд тухайн орон нутагт багшлах ёстой.	
	Сургалтын тэтгэлэг олгох журам		<ul style="list-style-type: none"> - Ахмаас чадвартай боловч төлбөрийн чадваргүй этгээд - Гоц авьяастай - Их сургуулийн газар тариалангийн салбарт суралцаж төгсөөд тухайн салбарт ажиллах хүсэлтэй 	
10. Япон	Боловсролын суурь хуудсийн хууль	<ul style="list-style-type: none"> - Хүүгүй эзэл - Хүтэй эзэл - Тэтгэлэг - Амжилгайн Гадаад оюутны буцалтгүй тусламж буюу тэтгэлэг <ul style="list-style-type: none"> - Бакалаврын - Магистрын - Докторын 	<ul style="list-style-type: none"> - 2004 оны 4 сараас өмнө дунд сургууль болон мэргэжлийн боловсрол олгох коллеж, Их Сургууль, технологийн коллежид элсэн өрсөм байх -Эдийн засгийн хувьд суралцах боломжгүй 	Японы засгийн газрын JASSO байгууллага

11. Монгол улс	Боловсролын тухай хууль 39.7-д /ерөнхий заалт/	Орсон нутгайг боловсон хүчинээр хангах, чуулал хэрэгцээтэй мэргэжилтэн балгах, суралцагчийн авьяасыг дэмжих, өргөсө багатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшэхэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.	-	бүтнээр болон халаслан зээлээс чөлөөлнө. Хүүтэй зээлийн хувьд нас барсан, бие махбодын болон сэтгэл мэдрэлийн чадваргүй бол төлөх боломжгүй бөгөөд зээлээс чөлөөлнө.	-
Дээд боловсролын тухай хууль /19 дүгээр хуульд хуульчилсан шалтгуурыг 3Г-ын 177-р тогтоол, 201-р тогтоолд журамласнаар зохицуулна./	19.1. Боловсролын тухай хуулийн 43.2.1-д заасны дагуу дотуур байраар үйлчилнэ. 19.2. хэглэлэг, буцалтгүй тусламж.	- Оршин суугаа газраасаа сургуулиаа тогтмол нээх боломжгүй суралцагчид - Өнчин, тахир дутуу болон амьжиргааны баталгааг түвшингээс доогуур орлоготой ерхийн болон бусад шаардлагатай суралцагчид - Сургалт, эрдэм шинжилгээний амжилд амжилт гаргасан суралцагчид	Сургалтын төрийн сан хариуцан 3Г-ын 177-р тогтоолоор баталсан "Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-аар зохицуулна.	Суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох журмыг Засгийн газар тогтооно.	

	Сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй эзэл олгоно. 13.3. нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөдүүлэн дэмжих. 19.5. улирлын болон төгсөлтийн шалгалт өгөх, дипломын ажиг бичиг хамгаалахад зориулж цалинтай чөлөө олгоно.	- Дээд боловсролын сургалтын байгууллагад эхнээ, өрхийн хэлбэрээр суралцагчид		- Ажлын газар нь
3Г-ын 177-р тогтоол	- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжаар	- Угсын хэмжээний олимпадад эхний 3 байр эзэлсэн оюутан - Олон улсын зэрэглэлийн олимпад, уралдаан, тэмцээнд МУ-ыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн - Бүтэн өвчин суралцагчийн - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг эх нь хойулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч - Өрхийн нэг хүнд ногдох орлого нь бусийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн - Өрхийн нэг хүнд ногдох орлого нь бусийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн	Эргэн төлөх нөхцөлгүйгээр олгогдоно. /Эдгээр бэлэгийг хэлэгсэн голч дүн 2.8-2.0-оос доошгүй байх шаардлага тавигдаат/	- Засгийн газар - БШСУЯ - СЗЗЯ - СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогддог/

		Суралцагчийн Хяналтын тоонд байгаан сургуулиа хоёсгод орон нутагт 3-аас дээш жил ажлахаар гэрээ байгуулсан суралцагчийн		Суралцагчийн Хяналтын тоонд байгаан сургуулиа хоёсгод орон нутагт 3-аас дээш жил ажлахаар гэрээ байгуулсан суралцагчийн	Эргэн төлөгдөх нөхцөлгүй олгогдоно.	Засгийн газар -БШСУЯ -СЭЭЯ -СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогддог/
		Амжилгааны хязгааргүй буцалтгүй тусламжаар		-ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын байгууллагад амжилгааны хязгааргүйгээр суралцаж байгаа МУ-ын иргэнд -ЗГ хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд	-төгссөнөөс хойш 5 жилийн дотор төлж барагдуулна, -ээдгийн гэрээгээ зөрчил ээдгийн хүүгийн хамт буцаан төлнө, -суралцагч нас барсан, хэргүйн төрийн чадвараа 70, түүнээс дээш хувиар алдсан бол ээдгийн төлбөрөөс чөлөөлнө, -нийслэлд төсвийн байгууллагад 5-аас доошгүй, орон нутагт мөн 3-аас доошгүй жил ажилласан бол эзлээс чөлөөлнө.	Засгийн газар -БШСУЯ -СЭЭЯ -СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогддог/
		-Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй эзлээр -Эрдэм шажмын хөнгөлөлттэй эзлээр -Бол малд амжилтунээр өрхийн нэг гшүүмд 100 хуртал төлөгөө мал ногдох зөвхөн малчин өрхийн суралцагч -Олон улсын нэр хүндтэн гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчид		Хялгас өнчин суралцагчид -Өрхийн нэг гшүүмд ногдох орлого нь бүсийн амжилгааны түүшмэлгээс доогуур орлоготой өрхийн суралцагч -Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч -Бол малд амжилтунээр өрхийн нэг гшүүмд 100 хуртал төлөгөө мал ногдох зөвхөн малчин өрхийн суралцагч -Олон улсын нэр хүндтэн гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчид	Эргэн төлөгдөх нөхцөлгүй	Төр хариуцаа, /сэндүүршил төрийн сангаар дамжин олгогддог/

Дүгнэлт, Санал Зөвлөмж

Дээрхи харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын хуулийн зохицуулалтаас дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Сургалтын төлбөрийг төр бүрэн хариуцдаг бөгөөд оюутны тэтгэлэг олгодог улс орон. Ийм бодлогыг баримталдаг улс оронд Турк, Энэтхэг, Швед, ОХУ, зэрэг улс орнууд багтаж байна. Тухайлбал Швед улс нь өөрийн орны оюутнуудын хувьд их сургуулийн үнсэн ангиудын сургалтын төлбөрийг төр хариуцах бөгөөд нийт оюутнуудад сар бүр тогтмол цалин олгодог байна. Тус цалин оюутны амьдрах зардалд зориулагдан олгогдох бөгөөд тэтгэлэгийг эхний ээлжинд нэг жилээр олгодог бөгөөд цаашид амжилттай сайн суралцсан тухай нотолгоо үзүүлсэн тохиолдолд цааш нь үргэлжлүүлэн олгодог. Гадаад оюутнуудын хувьд харилцан адилгүй шалгууртай байдаг бөгөөд оюутан солилцох гэрээ байгуулсан орнуудын хувьд шалгуур харьцангуй бага байдаг. Харин хуульд заасан болзол журмаар бакалавр болон магистрийн сургалтанд хамрагдаж байгаа гадаадын суралцагчид сургалтын төлбөр төлөхгүй боловч амьжиргааны тэтгэлэгт хамрагддаггүй байна. Турк улсын хувьд сургалтын төлбөрийг төр хариуцах бөгөөд оюутнуудын хувьд сургуульд бага хэмжээний хандив буюу “Contribution” төлдөг бөгөөд хуульд заасан үндэслэлийг хангасан оюутнууд сар бүрийн тэтгэлэгт хамрагдах эрхтэй болдог байна. ОХУ-д дээд боловсрол үндсэндээ төлбөргүй байх бөгөөд тодорхой нөхцөл шалгуур, журмын дагуу төлбөртэй сургалт явуулахыг л зөвшөөрдөг. Оюутанд тэтгэлэг өгдөг.
2. Сургалтын төлбөрийг оюутан хариуцах бөгөөд төрөөс оюутанд тэтгэлэг олгодог улс орон. Ийм улс оронд хууль болон журамд заасан үндэслэлийг хангасан оюутнуудын төлбөрийг улс хариуцах буюу буцалтгүй тусламж олгох бөгөөд бусад тохиолдолд оюутан сургалтын төлбөрийг өөрөө даадаг улс орныг хамруулж болно. Үүнд Япон, Солонгос, Казахстан, Австрали, Их Британи зэрэг улс орон багтаж байна. Тухайлбал, Англи улсын хувьд оюутны сургалтын төлбөрийн зээл болон, хоол байрны зардал зэрэг амьжиргааны тэтгэлэгийг Засгийн газраас “Grant” буюу дэмжлэг хэлбэрээр авдаг хуулийн зохицуулалт үйлчилж байна. Оюутны тэтгэлэгийн хэмжээг Higher Educatuin act, part4 Student support act-д заасны дагуу тухайн жилийн амьжиргааны түвшинг харгалзан Засгийн газраас тогтоодог байна. Австрали улсын хувьд оюутанд олгох тэтгэлэг болон бусад дэмжлэгийг гадаад, дотоодын оюутан тус бүрээр зохицуулсан Student assistance act, Education services for Overseas Students act зэрэг хуулиудаар тусгайлан зохицуулж байна.
3. Сургалтын төлбөрийг оюутан хариуцах бөгөөд тэтгэлэг олгодоггүй улс орон. Үүнд хууль болон Засгийн газраас тогтоосон дүрэм журманд тусгайлан зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн болон хувийн өмчийн аль ч сургуульд сургалтын төлбөрийг оюутан хариуцдаг. Түүнчлэн төрөөс бүх оюутанд хуульд заасан журмаар тэтгэлэг олгодоггүй улс орныг ойлгож болно. Үүнд Беларусь улс болон манай улсыг хамааруулж болно.

Сүүлийн жилүүдэд манай орны хувьд мэргэжлийн боловсрол олгож буй сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагчдад зориулсан сар бүрийн амьжиргааны тэтгэлэг болох 45 мянган төгрөгийг олгож байгаа юм. Энэ нь хүүхдүүдийн сурах идэвхийг нэмэгдүүлж, хичээлд хамрагдах нийт суралцагчдын ирцэд сайнаар нөлөөлж байгаа нь практикаас харагдаж байна.

Аль ч улс орны хувьд сурч боловсрох таатай орчин бүрдсэн тохиолдолд чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэх боломж хангагдах бөгөөд тэр хирээр ажил олгогчдын шаардлагыг хангасан ажиллах хүч нэмэгдэнэ гэж үзэх үндэслэлтэй юм. Түүнээс гадна оюутнуудыг хичээлдээ бүрэн хамрагдах нэг хүчин зүйл нь тэтгэлэг байхаар зохицуулж

болно гэж үзэж байна Иймд судалгаанд хамрагдсан Япон, Солонгос, Их Британи, Казахстан зэрэг улс орны эрх зүйн зохицуулалтын ерөнхий жишгийг харгалзан үзэж оюутнуудад ном сурах бичигтээ зарцуулахад нь зориулж, тодорхой шалгуураар олгох сар бүрийн, тогтмол тэтгэлэгт хамруулах бодлого баримтлах асуудлыг төрөөс анхаарч үзэх үндэслэлтэй юм.

* * *

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Боловсролын тухай хууль
2. Дээд боловсролын тухай хууль
3. Засгийн газрын тогтоолууд /ЗГ-1993-107,ЗГ-1995-194,ЗГ-1997-179,ЗГ-2000-96,ЗГ-2000-158,ЗГ-2000-201,2001-195,ЗГ-2002-207,ЗГ-2003-61,ЗГ-2003-139,ЗГ-2008-177,ЗГ-2008-178/
4. БСШУЯ-ны сайдын хамтарсан тушаал /2000-310/290тоот тушаал,2008-451/318тоот тушаал/
5. УИХ-ын ЭЗБХ-ны саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан 2007 он
6. МУ-ын Боловсролын тогтолцоо ба сургалтын төрийн сан: “Тогтвортой ирээдүйг бий болгох” судалгааны тайлан 2004 он
7. Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны тайлан 2008 он
8. Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан хөрөнгийн судалгаа 2008 он
9. Сургалтын төрийн сангийн зээл, тусламжид хамрагдагсдын судалгаа 2008 он
10. Монгол улсын дээд боловсролын мэдээлэл 2008 он
11. “Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн мониторинг судалгаа” 2007 он /Зориг сан Нээлттэй нийгэм Форум/
12. “Боловсрол” УИХТГ-ын номын сангийн сонингийн эмхэтгэл 1,2-р боть
13. “Боловсролын тогтолцоо олон улсад” Ч.Пүрэвдорж. УБ., 1999 он
14. “Америкийн дээд боловсрол” Д.Бадарч. УБ., 1999 он

Гадаад хэл дээрхи:

Турк улсын хуулиуд:

- Үндэсний боловсролын тухай хууль
- Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллагын тухай хууль
- Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль
- Тэтгэлэг, зээлийн журам

Их Британийн хуулиуд:

- Higher Educatuin act, part4 Student support act
- Education act 2002
- The Education (Grant) Regulations1990
- Education (Training Grants) Regulations 1990

Авсртали улсын хуулиуд:

- Student assistance act 1973
- Education services for Overseas Students (Assurance Fund Contributions) act 2000

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

- State Grant (Advanced Education) Act 1976

Энэтхэг улсын хуулиуд:

- Central Education Institutions (Reservation and Admission) Act 2006
- The University Grants Commission Act 1956, rules and regulation under the act

Швед улсын хуулиуд:

- Шведийн Боловсролын хууль

Бусад

- №125-ФЗ Дээд болон дээд боловсролын дараахь боловсролын тухай-ОХУ
- Боловсролын тухай хууль-БНКаЗУ
- Дээд боловсролын тухай хууль-БНБелУ
- Боловсролын суурь хууль -Солонгос
- Боловсролын байгууллагын албан хаагчдын хууль- Солонгос
- Сургалтын тэтгэлэг олгох журам-Япон
- Боловсролын суурь \үндсэн\ хууль- Япон

Website:

1. www.Edulaws.pmis.gov.mn
2. www.pmis.gov.mn
3. www.student.org.mn
4. www.iltod.gov.mn
5. www.forum.mn



UIH.MN
СУДАЛГААНЫ САН